



**НИЙСЛЭЛИЙН
АГААРЫН БОХИРДЛЫГ БУУРУУЛАХ ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2018 оны 10 сарын 11 өдөр

Дугаар A/39

Улаанбаатар хот

Г Унэлгээний хороо байгуулах тухай Г

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1 дэх заалт, 47 дугаар зүйлийн 47.3, 47.4 дэх заалтууд, Нийслэлийн Засаг даргын 2018 оны А/913 дугаар захирамжийг үндэслэн ТУШААХ НЬ:

1. Нийслэлийн агаарын бохирдлыг бууруулах зорилтын хүрээнд Улаанбаатар төмөр замын зорчигчийн вагоны галлагааны зуухнаас гарах утааг бууруулах дэвшилтэт технологи нэвтрүүлэх туршилтын ажлыг гүйцэтгэх аж ахуйн нэгж, байгууллагыг сонгон шалгаруулах “Унэлгээний хороо”-г дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Унэлгээний хорооны дарга

Д.Ганбат

Нийслэлийн Засаг даргын тамгын газрын
Бодлого, төлөвлөлтийн хэлтсийн
мэргэжилтэн

Гишүүд: Ч.Дамбасүрэн

Нийслэлийн Байгаль орчны газрын Ойн
хэлтсийн ахлах мэргэжилтэн

Ц.Сэргэлэн

Нийслэлийн Худалдан авах ажиллагааны
газрын Худалдан авах ажиллагааны
хэлтсийн мэргэжилтэн

Г.Анхбаяр

Монгол-Оросын хувь нийлүүлсэн
нийгэмлэг Улаанбаатар төмөр замын
тендер зохион байгуулалтын менежер
/зөвшилцсноөр/

Г.Ганболор

Монгол-Оросын хувь нийлүүлсэн
нийгэмлэг Улаанбаатар төмөр замын
тендер зохион байгуулалтын менежер
/зөвшилцсноөр/

Б.Батманлай

БГД-ийн 8-р хорооны иргэн

Нарийн бичгийн дарга:

Ж.Амармаа

Нийслэлийн Агаарын бохирдлыг
бууруулах газрын Захиргааны хэлтсийн
мэргэжилтэн

2. Худалдан авах ажиллагааг холбогдох хууль, тогтоомжийн дагуу зохион
байгуулж ажиллахыг Үнэлгээний хороо /Д.Ганбат/ -нд үүрэг болгосугай.

